



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудит хийх үндэслэл: Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, YAG-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр төлөвлөн баталж бүрдүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Зуунмод 2017 он

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Ц.Хишигжаргал

Аудитын менежер
О.Амаржаргал

Аудитор
Д.Пүрэвсүрэн
Шинжээч
Ч.Загдсүрэн

2017 оны 04 дугаар сарын 28

Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү.
www.tuv-audit.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70272287, дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Төв аймаг
Төр захигааны 2-р байр

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлж, хуваарилан зарцуулсан байна.

- 1.1 Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг хууль, журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.
- 1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг зөвхөн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс олгох орлогын шилжүүлгээр тооцож төлөвлөсөн байна.
- 1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хоёр нэр төрлөөр бүрдүүлсэн байна.
- 1.4 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Бүлэг 2. Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдээгүй байхад ОНХСангийн төлөвлөгөөнд тусган төлөвлөж хийж гүйцэтгүүлсэн байна

- 2.1 ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн байна.
- 2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумдад багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн байна.
- 2.3 Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй байхад ОНХСангийн төлөвлөгөөнд суулган төлөвлөн хийж гүйцэтгүүлсэн байна.
- 2.4 Аймгийн Боловсрол соёлын газарт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- 2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл арга хэмжээ болох Төрийн бус байгууллагад 19.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.
- 2.6 ОНХСангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажилд захиалагчийн хяналт тавих асуудал хангалтгүй байна.
- 2.7 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээ, хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэл тайланд цаг хугацаанд нь бүрэн гүйцэд тусгаагүй байна.

Бүлэг 3 ОНХСангийн хэрэгжилтийн явцад Аймгийн ИТХ-аас ажлын хэсэг томилон хяналт шалгалт хийсэн байна.

- 3.1 Аймгийн ИТХ-аас ажлын хэсэг томилон ОНХСангийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийлгэн дүнг хэлэлцэн ИТХТэргүүлэгчдийн тогтоол гарган хэрэгжүүлж ажилласан байна.
- 3.2 ОНХСангийн жилийн эцсийн тайланд зааврын дагуу тусгайлан дүн шинжилгээ хийсэн зүйл байхгүй байна.
- 3.3 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын болон төлөвлөгөө гүйцэтгэлийг зохих заавар журмын дагуу ил тод мэдээлж байна.
- 3.4 Орон нутгийн хөгжлийн сангийн заавар нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.
- 3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн нэг албан шаардлагаас бусад нь бүрэн хэрэгжсэн байна.

Дүгнэлт
Зөвлөмж
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга
хэмжээ

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТББ	Тендерийн бичиг баримт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт:

2016 оны ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрхи зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу нэр төрлөөр төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХНС, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХААГ, ГХБХБГ, баг хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзнэ.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

2016 оны “Төсвийн тухай хуульд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 131.0 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар 120.3 тэрбум төгрөг болгон өөрчилсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг тооцохдоо Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж ажилласан байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах тухай журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10-р сарын 14-ны өдрийн 2-р хуралдааны 02 тоот аймгийн 2016 оны төсвийг тодотгон баталсан тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох нийт шилжүүлэгийг 6300.9 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс аймгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3323.2 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд 2977.7 сая төгрөг олгохоор төлөвлөн батлагдсан байна.

Аймаг, сумдын ОНХСангийн санхүүгийн тайлангаар аймгийн ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрийг 3323.2 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2620.3 сая төгрөгөөр 42 төсөл хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, сумдын ОНХСангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төсөл арга хэмжээг 2977.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2070.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан нь 2016 онд 93.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байж улсын төвлөрсөн төсвөөс ОНХНСангийн орлогын шилжүүлгээр 3827.1 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 3.6 сая төгрөг, нийт 3830.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж үүнээс 2620.3 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 1304.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сумдын ОНХНСангийн тайланд оны эхэнд 369.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байж ОНХНСангийн санхүүжилтээр 2473.8 сая төгрөгийн, хуулинд заасан бусад эх үүсвэрээр 57.3 сая төгрөгийн, нийт 2531.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж 2070.6 сая төгрөгийг зарцуулж 830.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Эрсдлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, харьцуулах, дүн шинжилгээ, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглана.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитын хугацаа:

Аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 18-нд эхэлж, 5 дугаар сарын 1-ний дотор дуусгаж Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар хүргүүлнэ.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Д.Пүрэвсүрэн, шинжээч Ч.Загдсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, хоёрдугаар бүлэгт сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, гуравдугаар бүлэгт зарцуулалтад тавих хяналт, тайлагналын талаар тусгана.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөн, бүрдүүлсэн боловч, батлагдсан хуваарийн дагуу хуваарийн дагуу санхүүжүүлээгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймаг, нийслэлийн ОНХСангаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн үү?

Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг хууль, журмын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан 2016 оны 10 дугаар сарын улсын төсвийн тодотголоор аймгийн ОНХСангийн эх үүсвэрийг итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтаар 2351.5 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувиар тооцон 365.3 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн /мега төсөл/ 30 хувиар тооцон 2615.6 сая төгрөг, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлийн 50 хувиар тооцсоны 968.4 сая төгрөгөөр тус тус тооцон 6300.9 сая төгрөгөөр хуваарилжээ.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10-р сарын 14-ны өдрийн 2-р хуралдааны 02 тоот тогтоолоор аймгийн 2016 оны төсвийг тодотгон баталсан байна.

Тус тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох нийт шилжүүлгийг 6300.9 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс аймгийн орон нутгийн хөгжлийн санд 3323.2 сая төгрөг буюу 52 хувийг, сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2977.7 сая төгрөг буюу 48 хувийг олгохоор төлөвлөн батлагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, 59.4, 60.2 дахь заалт Засгийн газрын 30-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тус тус тооцож төлөвлөсөн байна. Үүнд:

1. Сумын хүн амын тооны нэгдсэн индекс
2. Сумын хүн амын тоо,
3. Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ,
4. Орон нутгийн татварын идэвх санаачлагын индекс гэсэн үзүүлэлтийн дагуу тооцон аймаг, сумын ИТХ-аар төлөвлөн баталж, сар улирлын хуваарийг аймгийн Засаг даргын захирамжаар баталсан байна.

1.2 Аймаг, нийслэл сум дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн үү?

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг зөвхөн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс олгох орлогын шилжүүлгээр тооцож төлөвлөсөн байна.

Тус журмын 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх, 6.1.3-т заасан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар

бий болгох эх үүсвэр, 6.1.4 –д заасан зарлагыг хэмнэх замаар бий болсон эх үүсвэр, 6.1.5-д тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж зэрэг эдгээр дөрвөн нэр төрлийн эх үүсвэрүүд манай аймагт гараагүй тул зөвхөн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс олгох орлогын шилжүүлгээр тооцож төлөвлөсөн байна.

1.3 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймаг, нийслэл сум, дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл тус бүрээр бүрдүүлсэн үү?

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хоёр нэр төрлөөр бүрдүүлсэн байна.

Манай аймгийн хувьд “Төсвийн тухай хууль”-д заасан ОНХНС-ийн таван эх үүсвэрээс зөвхөн нэг эх үүсвэр буюу ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэгийн 6300.9 сая төгрөгөөр бүрдсэн байна. Үүнээс гадна 2013 оны аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдааны /12 сарын 03/ 1 тоот тогтоолын 11-д “Газрын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хангах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгдчийн 2012 оны 77 дугаар тогтоолын дагуу төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-д, 50 хувийг тухайн сумын “Орон нутгийн хөгжлийн сан” болон төсөвт хуваарилан олгохоор тогтоосугай” гэж заасны дагуу 60.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Нийт 6361.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлжээ.

1.4 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн болон аймаг, нийслэлийн ОНХС-аас олгосон шилжүүлгийг хууль, журмын дагуу хуваарилж, батлагдсан хуваарийн дагуу олгосон уу?

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59.3 дахь заалт, Засгийн газрын 30 дугаар тогтоолоор баталсан аргачлал, Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан журмыг баримтлан аймгийн ИТХ-аар батлуулан хуваарилсан байна.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг 6300.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс аймагт 3323.4 сая төгрөг, суманд 2977.5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг батласан. Гэвч гүйцэтгэлээр 3 суманд батлагдсан хуваариас 503.7 сая төгрөг дутуу, аймгийн ОНХС-д 503.7 сая төгрөг илүү олгожээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн үү?

Бүлэг 2

Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдээгүй байхад ОНХСангийн төлөвлөгөөнд тусган төлөвлөж хийж гүйцэтгүүлсэн байна

2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгэсэн үү?

ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөж батласан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил нь аймгийн хөгжлийн хөтөлбөр /2008-2023 он/, аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2016 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан батлажээ. Мөн сумдын Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн дагуу багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн иргэдээс авсан саналыг сумын ЗДТГазар эрэмбэлэн өргөн мэдүүлсэн жагсаалтын дагуу сумын ИТХ-аараа ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг батлуулсан байна.

2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлсэн үү?

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумдад багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал авч, эрэмбэлэх асуудал хангаттай хийгдээгүй байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтыг аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зорилго зорилттой уялдуулан эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, төсвийн төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна

Сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр дараагийн жилд хийгдэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдийн саналыг авч багийн ИНХ-аар хэлэлцүүлэн, эрэмбэлсэн жагсаалтыг сумын ЗДТГазарт нэгтгэн ИТХ-д өргөн барьж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил, төсөл арга хэмжээний жагсаалтыг батлуулжээ. Гэвч дараахь зөрчил гарлаа. Жишээлбэл:

-Зуунмод сумын зургаан багаас зөвхөн 3, 5 дугаар багийн ИНХ-аар оны эцсийн багийн дарга нарын ажлын тайланг хэлэлцэх үед гарч байсан санал, хурлын протоколыг үндэслэн 2016 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил буюу тус багуудад 111.7 сая төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг хийхээр сумын ИТХурлаараа баталжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн иргэдийн саналыг авч багийн ИНХ-аас хэлэлцүүлэн эрэмбэлсэн жагсаалтыг ЗДТГазарт нэгтгэн эрэмбэлж сумын ИТХ-аар хэлэлцүүлэн төсвийн төсөлд тусган батална гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Зуунмод сум нь уг зөрчлийг давтан гаргасан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаар Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Аудитын төлөвлөгөөний 7 дугаар хавсралтаар

ирүүлсэн санал асуулгын маягтын дагуу 27 сумын нийт 10723 иргэнийг хамруулсан судалгааг хийлээ. Санал асуулгад нэг сумаас дундажаар 397 хүнийг хамруулж, нэгтгэгдлээ. Сумдаас Зуунмод сум хамгийн олон буюу 4331 иргэн, Сэргэлэн сум хамгийн цөөн буюу 30 иргэнийг санал асуулганд хамруулсан байна.

Санал асуулга авсан хуудсыг нэгтгэн дүгнэлт хийж үзэхэд:

1.ОНХСангийн санхүүжилтийн ямар төсөл, арга хэмжээ танай баг хороонд хэрэгжиж буй талаар хэрхэн мэдээлэлтэй байна вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг авч үзвэл санал асуулгад оролцогчдын 40.6 хувь нь хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг сайн мэднэ, сонссон боловч хэрэгжиж буйг мэдээгүй 35.7 хувь, энэ талаар огт мэдээлэлгүй гэж 13 хувь нь хариулснаас үзэхэд энэ талын мэдээллийг иргэд хангалттай сайн мэдэхгүй байгаа тул хойшид ОНХСангийн санхүүжилтээр ямар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлж байгаа талаар иргэдийг мэдээллээр хангах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

2.ОНХСангийн асуудлыг хэлэлцэх багийн иргэдийн нийтийн хуралд та оролцож байна уу? гэсэн асуултын хариулсан байдлыг авч үзвэл 19.4 хувь нь байнга, 58.3 хувь нь хааяа, 22.5 хувь нь огт оролцдоггүй гэж хариулсан байдлаас харахад багийн иргэдийн нийтийн хуралд оролцох оролцоо төдийлөн хангалттай биш байна. Иймд багийн иргэдийн нийтийн хуралд иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол? гэсэн асуултанд оролцогчдын 21.5 хувь нь цаанаасаа бэлтгэсэн асуудлуудын жагсаалтыг хэлэлцүүлж санал авдаг, 2165 хувь нь оролцогч иргэдээс санал авч дэвшүүлэн хэлэлцүүлдэг, 25.6 хувь дээрх хоёрын аль аль нь, 27.9 хувь нь иргэдийн саналыг бараг сонсдоггүй, нэр төдий хурал болдог гэж хариулсан байна.

4.ОНХСангийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу? гэсэн асуултанд 34.0 хувь нь тийм, 48.5 хувь нь зарладаг байх гэхдээ би сонсоогүй гэж, 17.6 хувь нь огт үгүй гэж хариулсан нь багийн удирдлагын зүгээс зарладаг боловч иргэд өөрсдөө идэвхтэй очиж оролцох тал дээр хангалтгүй байгааг харуулж байна.

5.ОНХСангаас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу? гэсэн асуултанд 26.9 хувь нь саналын хуудас мэдээлэл байнга ирдэг, 45.2 хувь нь саналын хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл ирдэг, 28.3 хувь нь саналын хуудас ирдэггүй, мэдээлэл ч өгдөггүй гэж хариулсан байна.

6.ОНХСангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтанд иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу? гэсэн асуултанд 37.6 хувь нь бүрэн боломжтой, 24.1 хувь нь боломжгүй, 38.3 хувь нь энэ талаар мэдэхгүй байна гэж хариулсанаас үзэхэд ихэнх иргэд буюу 38.2 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээ төлөвлөлт, зарцуулалтын талаар аймаг, сумдын ЗДТГазар, багийн Иргэдийн нийтийн хурал, багийн засаг даргын зүгээс иргэдэд мэдээллийг хүргэх, тэдний саналыг тусгах, иргэдийн оролцоо тэдгээрийн хяналт тавих боломжийн талаар дээрх санал асуулгын хуудсанд хариулсан дүнгийн нэгтгэлээс харвал Төсвийн тухай хууль, түүнийг дагалдаж гарсан ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, зарцуулах журам, заавруудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна. /Хүснэгт-7/

2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтын шаардлагыг хангасан ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан уу?

Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй байхад ОНХСангийн төлөвлөгөөнд тусган төлөвлөж, хийж гүйцэтгүүлсэн байна.

2016 онд аймгийн болон сумдын ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр нийт 6847.5 сая төгрөгийн 274 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар батласнаас урд оны 30 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 989.5 сая төгрөг, тайлант оны 244 төсөл, арга хэмжээнд 5858.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор батлажээ. Тайлант онд 4372.9 сая төгрөгийн 177 төсөл, арга хэмжээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан байна. Гэвч хууль тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдээгүй зарим төсөл арга хэмжээг ОНХСангийн төлөвлөгөөнд тусган баталж, хийж гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.7 дахь заалтыг зөрчсөн байна. Жишээлбэл:



- Мөнгөнморьт сумын 150.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Зүүн бүрхийн голын гүүр барих ажлыг зураг, төсөвгүй хийж 2016 оны 9 сард аймгийн ИТХ-аас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж шалгасны дараа зураг төсвийг гүйцэтгэлдээ нийцүүлэн 15.0 сая төгрөгөөр Хагд ХХК-иар нөхөн хийлгүүлсэн.

- Аймгийн Засаг даргын 2016.07.01-ний А/361 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн дадлагын хичээлийн 46.0 сая төгрөгийн байрны засвар, CNC суурь машин тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг зураг, төсөвгүй хийж гүйцэтгүүлсэн.


- Аймгийн баяр наадмын зардалд тус сангаас 25.0 сая төгрөг төлөвлөн зарцуулсныг судалж үзэхэд аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэнгийн гадна тохижилт засвар, явган хүний зам тавих ажлыг зураг төсөвгүйгээр хувь хүмүүс, иргэдээр гүйцэтгүүлсэн,

- Баяндэлгэр суманд хэрэгжсэн 63.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ЭМТ-ийн барилгын дээврийн засварын ажил, 50.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар, Борнуур сумын соёлын төвийн 85.0 сая төгрөгийн төсөвтэй их засварын ажил, Зуунмод сумын худалдааны гудамжны тохижилтын 74.7 сая төгрөгийн ажлууд нь зураг төсөвгүйгээр хөрөнгийн эх үүсвэр батлагдаж, 2016 онд төсөв батлагдсаны дараа зураг төсөв нь хийгдсэн байна.

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Аймгийн Боловсрол соёлын газарт хэрэгжүүлсэн 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Аймаг сумдын ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр 5858.0 сая төгрөгийн 244 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1535.8 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ, харьцуулалтын аргаар 1891.8 сая төгрөгийн 39 төсөл, арга хэмжээ, шууд худалдан авалтын аргаар 1124.4 сая төгрөгийн 122 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТухай хууль, түүнийг дагалдаж гарсан журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. /Хүснэгт №3/



Аймаг сумдын ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр 2016 онд хийгдсэн ажлуудын тендерийн урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу цаг тухай бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинд нийтэлж, цахим хуудас болон Сангийн яамны “e-procurement.mof.gov.mn”, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны албаны

“procurement.to.gov.mn” сайт, байгууллагын мэдээ, мэдээллийн самбар, иргэний танхим дах худалдан авах ажиллагааны албаны самбар, шилэн дансны сайт, аймгийн “tov.gov.mn” сайтад тус тус байршуулан тендерт оролцохыг сонирхогчдод тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор ханган мэдээллийг ил тод нээлттэй тавьж ажилласан байна.

Нийцлийн аудитын явцад төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан боловч зарим зөрчил илэрснийг дурьдвал:

-Зуунмод хотын Ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн хичээлийн дадлагын байрны засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж CNC суурь машин суурилуулах 46.0 сая төгрөгийн ажил, Хүмүүн цогцолбор сургуулийн дизайн технологийн танхимын дадлагын ажилд шаардагдах тоног төхөөрөмж олон үйлдэлт принтер, бүрэгч машин дагалдах цаас хэрэглэлийн хамт 17.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлдэцийг, мөн 15.0 сая төгрөгийн үлээвэр хөгжмийг худалдан авахдаа шууд худалдан авсан,

-Сэргэлэн сумын ОНХСангийн хөрөнгөөр дөрвөн гүн өрмийн худгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь Ханбулгийн эх ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, сумын Засаг даргад тус ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Гэтэл уг зөвлөмжийн дагуу Ханбулгийн эх ХХК-тай бус гүний худаг гаргах мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй Нэгүн хаус ХХК-тай гэрээ байгуулсан.

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад ТАХ-д сангийн хөрөнгийг зарцуулсан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан 244 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.2-т “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 60.3-т “ОНХСангийн хөрөнгийг дараахь зүйлд зарцуулахыг хориглоно”. Үүнд: 60.3.1-т “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ” гэсэн заалтуудыг мөрдөж ажилласан байна.

Гэхдээ зарим нэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дээрхи хуулийн заалтыг зөрчин орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ. Үүнд:

-Аймгийн Засаг даргын захирамжаар Хүмүүн цогцолбор сургуулийн технологийн танхимын дадлагын ажилд шаардагдах тоног төхөөрөмж болох олон үйлдэлт принтер, бүрэгч машин дагалдах цаас хэрэглэлийн хамт 17.сая төгрөгөөр, мөн аймгийн Засаг даргын захирамжаар ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн сургалтанд

хэрэглэгдэх 500 ширхэг модон бэлдэц, 72 ширхэг зэс хөөмөлийг 2.0 сая төгрөгөөр, нийт 19.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бэлдэцийг Нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Нямсүрэн Зуунмод сумын Залуу зохион бүтээх төвийн захирал С.Дарьмаатай гэрээ байгуулан тус төвд 19.0 сая төгрөгийг шилжүүлжээ. Тус тоног төхөөрөмжийг Төрийн бус байгууллага болох Залуу зохион бүтээх төвийн хөрөнгийн данс бүртгэлд бүртгэсэн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл арга хэмжээнд зарцуулжээ. Энэхүү тоног төхөөрөмжийг ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн сургалтын дадлагын хичээлд зориулалтын дагуу ашиглаагүй байгаа нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн төсвийн хөрөнгийн үр ашиг харагдахгүй байна.

- Баян суманд аймгийн шүүхийн шийдвэрээр иргэн Б.Болдбаатарт төлөх газрын төлбөр 12.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-аар төлүүлэх шийдвэр гарсан байна. Уг төлбөрийг сумын Засаг даргын “Зардал гаргах тухай” захирамжаар сумын ОНХС-аас гаргахыг шийдвэрлэж, Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн,

- Эрдэнэ сумын ОНХС-аас 19.8 сая төгрөгөөр сумын өвс, тэжээлийн фонд бүрдүүлсэн зэрэг зөрчлүүд нь ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмч байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6-р зүйлийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнах”, 6.4.2-т “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 60.3-т ОНХСангийн хөрөнгийг дараахь зүйлд зарцуулахыг хориглоно. Үүнд: 60.3.1-т “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон уу?

ОНХСангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналт тавих асуудал хангалтгүй байна.

Аймаг, сумын хэмжээнд 2016 онд нийт 5858.0 сая төгрөгийн 244 төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 176 төсөл, хөтөлбөрт 3763.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 3731.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон байна.

Сумдуудын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж буй ажлын хувьд захиалагчийн хяналт буюу сум, орон нутгаас хяналт тавих ажил хийгдэж байгаа боловч зарим сумдад хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу хийж, захиалагчийн хяналт хийсэн тухай баримт материал бүрдүүлсэн байдал шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Аудитын явцад бараа ажил үйлчилгээ худалдан авах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавьж санхүүжилтийг олгоогүй зөрчил илэрсний заримыг дурьдвал:



- Сүмбэр сумын 701.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй, он дамжсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын захиалагчийн эрхийг суманд нь шилжүүлсэн боловч захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавиагүйгээс ажлын гүйцэтгэл 50 хувьтай байхад 70 хувийн санхүүжилтийг олгосон,

-Цээл сумын 150.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй Хөдөө аж ахуйн машины засварын газрыг аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлэх ажлын урьдчилсан санхүүжилтийн гэрээг байгуулжээ. Аймгийн ЗДТГазрын ХБХэлтсийн дарга, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нар санхүүжилтийн зөвшөөрөл мэдэгдэл өгснөөр, ХАА-н машины тоног төхөөрөмж эд ангиудыг сэргээн засварлах цех байгуулах ажлын урьдчилгаанд 45.0 сая төгрөгийг Дархан үйлс ХХК-д шилжүүлсэн байна. Тус ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгахад захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавиагүйгээс гүйцэтгэгч Дархан үйлс ХХК нь гэрээний хугацаанд ажлаа хийгээгүй, гүйцэтгүүлээгүй, ажил нь зогссон,

-Зуунмод сумын Лансын 2 дугаар багийн гудамжны гэрэлтүүлгийн ажлыг 75.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээтэй Хас барс ХХК-иар хийж гүйцэтгүүлж, 574 ширхэг шонтой лед гэрлийг ашиглалтанд оруулах комиссын актаар хүлээж авсныг, газар дээр нь очиж шалгаж үзэхэд 242 гэрэл асч нийт гэрлийн 58 хувь нь буюу 332 гэрэл асахгүй байна.

Энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх явцад зураг, төсөвт тусгасан материалаар, гэрээний дагуу хийж байгаа эсэхэд захиалагчийн хяналтыг хууль журмын дагуу тавиагүйтэй холбоотой байна.

-Сэргэлэн сумын гүн өрмийн худгийн ажлын үе шатны ажлын гүйцэтгэл гараагүй, гэрээгээ дүгнээгүй, ажил нь дуусаагүй байхад 4 худгийн 40.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоос, санхүүжилтийн 88 хувь буюу 35.2 сая төгрөгийг олгосон,

-Заамар сумын удирдлагууд төлөвлөгөөт ажлаа хугацаанд нь хийж гүйцэтгэлгүйгээр халуун усны газрын засварын 12.6 сая төгрөг, сумын төвд цахилгааны шугам татах 94.9 сая төгрөг, цэвэрлэх байгууламжийн засвар 50.4 сая төгрөг, Төмстий багийн тохижилт 39.9 сая төгрөг зэрэг нийт 201.4 сая төгрөгийн 4 ажлыг хийж гүйцэтгүүлэхээр оны эцэст буюу 12 дугаар сард тендер зарлан, худалдан авах ажиллагаа явуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Эдгээр барилга, байгууламж, их засварын ажлыг хүйтний улиралд хийж гүйцэтгэх боломжгүй байхад гэрээ байгуулан үйл ажиллагаа эхлээгүй ажилд гэрээт ажил тус бүрийн санхүүжилтийн 80 хувийг олгож оны эцэст 161.1 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, Барилгын тухай хуулийн холбогдох заалтууд болон бусад заавар журмыг зөрчсөн байна.

-Мөн 10.0 сая төгрөгийн төсөвтэй Тосон багийн нутагт үлийн цагаан огтоно устгах ажлыг оны эцэст 12 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд газар хөлдүү үед хөөөнд ус зутган хийж, 10.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл гаргаж, санхүүжүүлжээ. Энэ нь захиалагчийн хяналтыг зохих ёсоор тавиагүйгээс төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх нь нотлогдохгүй байгаа тул хууль хяналтын байгуулгад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ

-Баян сумын дунд сургуулийн барилгын дээврийн засварын ажилд аймгийн ИТХ-ын тогтоолоор 60.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр “Дуулгат мөрөн” ХХК шалгарч 59.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж ажил гүйцэтгүүлсэн байна. Мөн Баян сумын ЗДТГ-тай сумын ОНХС-аас санхүүжих 39.8 сая төгрөгийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, ажлыг гүйцэтгэн санхүүжилт авсан байна. Уг ажлын зураг, төсвийг ажлын гүйцэтгэлтэй тулган үзэхэд нэг ажилд 2 гэрээ байгуулагдан 39.8 сая төгрөгийн санхүүжилтийг давхардуулан олгосон,

-Алтанбулаг сум Цэвэр усны шугамын ажлыг Ану сервис ХХК-аар гүйцэтгүүлэхээр 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 12 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Уг ажил хэрэгжих боломжгүй болж 6.0 сая төгрөг Ану сервис ХХК-аас эргэн төлсөн боловч үлдэгдэл 6.0 сая төгрөг төлөгдөөгүй,

-Эрдэнэ сум өмнөх онд гэрээ нь байгуулагдсан 24.5 сая төгрөгийн гэрээтэй ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлыг ажил хүлээлцэх комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон,

- Авъяас хөтөлбөрийн хүрээнд Бүрэн, Зуунмод, Эрдэнэ, Заамар сумдын сургуулиудын шигшээ багийн тамирчдын жагсаал, бэлтгэлийн үед хэрэглэх биеийн тамирын 80 ширхэг хувцасыг Боннтекстайл ХХК-иас худалдан авах гэрээг БСГ-ын дарга С.Нямдорж байгуулан, 4.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч аймгийн Засаг даргын захирамжийн хавсралтанд дурьдсан хуваарьт Бүрэн сумаас бусад сумын сургуулиудад 3.3 сая төгрөгийн 66 хувцасыг олгоогүй,

- Борнуур сумын “Эко орчин эрүүл амьдрал” ТББ-д 2016 оны 12 сарын 28-нд ажил гүйцэтгэх гэрээгүй, 26.5 сая төгрөг шилжүүлж, дансанд байршуулсан зэрэг зөрчил гарлаа.

Эдгээр нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “Барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, фото зургаар баталгаажуулсан ил далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах”, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Сангийн сайдын 2012 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам” 3.3, 3.9, 4.1, 4.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.7 Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд тусгасан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл арга хэмжээ, хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу бүртгэл тайланд цаг хугацаанд нь бүрэн гүйцэд тусгаагүй байна.

Нийцлийн аудитын явцад сумдын болон аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн бараа, ажил үйлчилгээ, төсөл арга хэмжээг холбогдох ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэл, санхүүгийн тайланд хууль, дүрэм, журмын дагуу ашиглалтанд хүлээн авах комисс байгуулан хүлээн авч орон нутгийн өмч хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байна.

Аймаг, сумдын 2016 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлыг 27 суманд газар дээр нь очиж үзэн, ашиглалтын болон данс бүртгэлд тусгасан байдлыг шалгалаа.

ОНХСангаас хэрэгжүүлж буй зарим төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ аймгийн Засаг даргын удаа дараагийн захирамжаар хэрэгжүүлэгч, ашиглагч байгууллагын дансаар дамжуулахгүйгээр бэлтгэн нийлүүлэгчийн дансанд шууд шилжүүлж санхүүгийн анхан шатны баримтыг дутуу бүрдүүлэх, гүйцэтгэлийн тайланг цаг тухайн үед нь гаргуулаагүй, нийлүүлж байгаа бараа, ажил үйлчилгээний хэрэгжилт, тоо, чанарт захиалагч, ашиглагчийн хяналт тавих боломжгүй болгох төдийгүй ашиглагч байгууллагын данс бүртгэлд хөрөнгөөр буюу авлагаар тусгагдахгүй байх зөрчил нилээд гарч байна

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу төрийн болон орон нутгийн өмчийн холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй зарим зөрчлүүд илэрснийг дурьдвал:

-ОНХСангаас аймгийн Засаг даргын Авъяас хөтөлбөрийн хүрээнд 46.0 сая төгрөгийн ерөнхий боловсролын сургуулиудын дизайн технологийн хичээлийн дадлагын байрны засвар үйлчилгээ, CNC суурь машин, тоног төхөөрөмжийг ажлыг Зуунмод сумын Баянхошуу багийн хуучин хүүхдийн цэцэрлэг байсан байранд хаалга гарган, өрөө тасалгаа, дээврийг будаж, цахилгааны утас татсан тухай гүйцэтгэл гарган, ажлыг хүлээн авсан акт үйлдсэн боловч жилийн эцсийн тайланд ашиглагч байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, зориулалтын дагуу ашиглаагүй,

- Хүмүүн цогцолбор сургуулийн технологийн танхимын дадлагын ажилд шаардагдах нийт 19.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бэлдэцийг Хүмүүн цогцолбор сургуульд бус Төрийн бус байгууллага болох Залуу зохион бүтээх төвийн хөрөнгийн данс бүртгэлд бүртгэсэн,

- Боловсрол соёлын газрын дэргэд үлээвэр хөгжмийн хамтлаг байгуулахаар шийдвэрлэсний дагуу 15.0 сая төгрөгийн үлээвэр хөгжмийг худалдан авсан боловч хаана ямар байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа нь тодорхойгүй, ашиглагч байгууллагынхаа орон нутгийн өмчийн данс бүртгэлд тусгаагүй байна. Тус хөгжмийг боловсрол соёлын газар, Жаргалант сумын ерөнхий боловсролын дунд сургууль, аймгийн хүүхэд залуучуудын Солонго төвөөр дамжин, эцэст нь Эрдэнэ сумын соёлын төвийн мэдэлд өгсөн нь тус хөрөнгийг цаг тухайн үед нь ашиглагч байгууллагад нь хүргүүлж зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаагүй байна.

-Сэргэлэн сумын Засаг дарга Т.Гансүх, Даймондтопаз ХХК-ий захирал Ц.Амарбаяр нар тус сумын 2-р багийн Баянбулаг гэдэг газарт гүн өрмийн худгийг 9.0 сая төгрөгөөр гаргуулахаар гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн, Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг ашиглалтанд хүлээн авч, худгийн санхүүжилтэнд аймгийн ОНХСангаас 8.8 сая төгрөгийг шилжүүлсэн боловч, сумынхаа орон нутгийн өмчийн данс бүртгэлд тусгаагүй,

-Дэлгэрхаан сум ОНХСангаас 3 иргэнийг малжуулах төсөлд хамруулж 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч данс бүртгэлд авлагаар тусгаагүй зэрэг зөрчил илэрлээ.

Эдгээр нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнах”, 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байх зэрэг хууль тогтоомж зөрчсөнд 33.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 392.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, нийт 425.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүллээ. Үүнээс өмч хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой 13.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 326.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан уу?

Бүлэг 3

ОНХСангийн хэрэгжилтийн явцад Аймгийн ИТХ-аас ажлын хэсэг томилон хяналт шалгалт хийсэн байна.

3.1 ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан уу?

Аймгийн ИТХ-аас ажлын хэсэг томилон ОНХСангийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийлгэн, дүнг хэлэлцэн ИТХТэргүүлэгчдийн тогтоол гарган, хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор ОНХСангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын явц байдалд хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулан бүрэлдэхүүнд нь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан аймгийн ИТХ-ын даргын баталсан тусгай удирдамжийн дагуу Аргалант, Баянцогт, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Борнуур, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Зуунмод зэрэг сумдад хяналт шалгалтыг хийсэн байна.

Тус ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу аймгийн 2016 оны ОНХСангийн төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалт, их засварын ажлын явцыг шалгасан дүгнэлт тайлангийн талаар ажлын хэсгийн ахлагчийн мэдээллийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 9 дүгээр сарын 21-ны хурлаар хэлэлцээд “Хөрөнгө оруулалт их засварын ажлын талаар авах арга хэмжээний тухай” аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 32 дугаар тогтоол гаргасан байна.

Тус тогтоолд аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, санхүүжүүлэх, хяналт тавих журам боловсруулах, Сангийн сайдын 264 дүгээр тушаалаар батлагдсан журмыг мөрдөж сумдын төлөвлөгөө, тайланг нэгтгэн аймгийн нэгдсэн төлөвлөгөө, тайланг боловсруулан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих, зураг төсөв нь хийгдээгүй ажлыг төсөвт тусгадаг дутагдлыг арилгах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулах, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, өндөр хариуцлага, санаачлагатай ажиллуулах зэрэг заалтуудыг тусгасан байна.

Сумдуудын ИТХурлаас ажлын хэсэг томилон ОНХСангийн хэрэгжилтийн явцад буюу жилийн эцэст хяналт шалгалт хийлгэдэг байна. Жишээлбэл:

-Зуунмод сумын ИТХурлаас 2016 онд аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэлийн байдалд сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 33 тоот тогтоолоор батлагдсан “Олон нийтийн аудит”-ын гишүүдээр хяналт шалгалт хийлгүүлэн дүгнэлт зөвлөмж өгч ажилласан байна.

Аймгийн Санхүү хяналт, аудитын алба 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу 15 сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийж эдгээрээс 13 сумын ОНХСангийн зарцуулалтанд зөрчил гараагүй байна. ОНХСангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил Цээл суманд 45.4 сая төгрөгийн, Аргалант суманд 4.9 сая төгрөгийн, үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй нийт

50.3 сая төгрөгийн зөрчлийг тус тус илрүүлэн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн акт бичигдсэн байна.

3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлж, тайланд дүн шинжилгээ хийсэн үү?

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын дагуу жилийн эцсийн тайланд тусгайлан дүн шинжилгээ хийсэн зүйл байхгүй байна.

Аймаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төлөвлөгөө, хэрэгжилтийн байдлыг сумдын Санхүүгийн албаны дарга, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан мэрэгжилтэнүүдээр сар бүрийн гүйцэтгэлийг гаргуулан, Сангийн яамны mof.gov.mn сайт дахь засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн ОНХСан гэсэн туслах цэсийн программд шивж оруулан хяналт тавьж ирсэн байна.

Сангийн сайдын тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2-д “Сум дүүргийн ОНХСангийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж, ОНХСангийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар томилж ажиллуулна” гэсэн заалтын дагуу хагас, бүтэн жилээр ОНХСангийн тайланг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, тайланд тусгайлан дүн шинжилгээ хийлгээгүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу ил тод мэдээлсэн үү?

Тус сангийн санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн программд оруулж төлөвлөгөө гүйцэтгэлийг зохих заавар, журмын дагуу ил тод мэдээлж байна.

Аймгийн хэмжээнд 27 сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 206, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 38, нийт 244 төсөл, арга хэмжээний тухай мэдээллийг Сангийн яамны Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн систем болон шилэн дансны мэдээлэлд оруулан иргэд, олон нийтэд үр дүн, үр нөлөөг хянах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Сумдын шилэн дансны самбар болон төсвийн ил тод байдлын самбараар мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн байдлыг Аймгийн Засаг даргын А/273 тоот захирамж болон Засаг даргын нэрэмжит үзлэгийн үеэр жилд 2 удаа шалган үр дүнг тайлагнасан байна.

Мөн Сангийн яамны mof.gov.mn гэсэн мэдээллийн санд аймаг сумын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээ, худалдан авалт хийсэн бараа, ажил үйдчилгээг орон нутгийн хөгжлийн сангийн программд оруулж тус сангийн зарцуулалтын болон төлөвлөгөө гүйцэтгэлийг зохих заавар журмын дагуу ил тод мэдээлж байна.

3.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар нь” бусад хууль, тогтоомжтой нийцсэн үү?

3.5 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, нэг албан шаардлага дутуу хэрэгжсэн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн 24.4 сая төгрөгийн 5 актыг 100 хувь, 1343.4 сая төгрөгийн 26 албан шаардлагыг 98.3 хувь, 6 зөвлөмжийг хугацаанд нь биелүүлж 2016 оны жилийн эцсийн статистик мэдээгээр гаргаж хүргүүлсэн болно.

Үүнээс дутуу хэрэгжилттэй байгаа нэг албан шаардлагыг дурьдвал:

Зуунмод сумын 2015 оны ОНХСангийн хөрөнгөөр зарим багийн Гэр хорооллын хашаануудын нүүрний хэсгийг сольж “Шинэ хашаа төсөл” хэрэгжүүлэхдээ айл өрхийн хувийн өмчлөлийн хашааны хаалгыг шинээр сольсны үнийг төлүүлж 28.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлагын 5.1 сая төгрөгийг барагдуулж, албан шаардлагын хэрэгжилт 22.9 сая төгрөгийн дутуу хэрэгжүүлээгүй үлдэгдэлтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүн, тайланд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Аймаг, сумдын хэмжээнд 2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож 6300,9 сая төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөн баталж бүрдүүлсэн байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг холбогдох хууль, журмын дагуу тооцож бүрдүүлэн аймаг, сумын хэмжээнд 5858.0 сая төгрөгийн 244 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуудан, иргэдийн саналыг тусган хэрэгжүүлж, санхүүжилтийг хуваарийн дагуу олгосон байна.

3.Зарим төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй байхад ОНХСангийн төлөвлөгөөнд тусган төлөвлөн, хийж гүйцэтгүүлэх, төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байх зэрэг өмнөх жилийн зөрчил давтагдсаар байна.

4. Аймгийн Боловсрол соёлын газрын болон зарим сумдын удирдлагууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийн хяналтыг хангалтгүй хийж, бэлтгэсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу зориулалт ёсоор ашиглаж, бүртгэл тайланд тусгаагүй зарим зөрчлүүд байна.

5. Сангийн яамны mof.gov.mn сайтын мэдээллийн санд аймаг сумын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээ, худалдан авалт хийсэн бараа, ажил үйдчилгээг орон нутгийн хөгжлийн сангийн программд оруулж тус сангийн зарцуулалтын болон төлөвлөгөө гүйцэтгэлийг зохих заавар журмын дагуу ил тод мэдээлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Нийцлийн аудитын тайлан, дүгнэлтэд үндэслэн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга А.Лхагвахорол нарт **Зөвлөх нь:**

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээнд хөрөнгийн эх үүсвэр батлуулахдаа хууль, тогтоомжийн дагуу зураг, төсөв хийгдсний дараа санхүүжилтийг батлуулах,

2.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТБОНӨХБАҮХАТухай хууль, түүнийг дагалдаж гарсан журмын дагуу зохион байгуулах

3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийн хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг дүгнэх зэрэг ажлуудыг хууль журмын дагуу хийж хэвшүүлэх

4.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн бэлтгэсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зориулалт ёсоор ашиглалтанд хүлээн авч, орон нутгийн өмч хөрөнгийн болон данс бүртгэлд цаг тухай бүрд тусган, энэхүү зөрчлийг давтан гаргахгүй байх.

5.Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах ажлыг зохион байгуулж биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлэх

Холбогдох байгууллагын санал



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**


41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273623, Факс: 70272237


2017.04.28 № 05/699
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн Аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нийцлийн аудитын тайлангийн дүгнэлт зөвлөмжийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах болно.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ю.БЯМБАЦОГТ

02 0589

My.doc: TootA5-2/2017

Акт, албан шаардлагын дугаар	Хариуцсан барагдуулагчийн нэр	Зөрчил төлбөрийн утга	Зөрчил төлбөрийн дүн /мян.төг/		Акт, албан шаардлага бүтсэн аудитор, шинжээч
			Акт	Албан шаардлага	
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/51	Боловсрол соёл урлагийн газар	Зарим ЕБС-иудад хуваарилагдсан биеийн тамирын хувцасыг хуваарийн дагуу олгоогүй	4,000.0		Д.Пүрэвсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/51	Эрдэнэ сумын Соёлын төв	Үлээвэр хөгжмийг данс бүртгэлд тусгаагүй		15,000.0	Д.Пүрэвсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/51	Сэргэлэн сумын ЗДТГазар	Гүн өрмийн худгийг данс бүртгэлд тусгаагүй		8,820.0	Д.Пүрэвсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-02/71	Боловсрол соёл урлагийн газар	Сургалтын тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй		46,000.0	Д.Пүрэвсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/70	Боловсрол соёл урлагийн газар	Сургалтын тоног төхөөрөмжийг ТББ-д өгсөнийг буцааж авах		19,000.0	Д.Пүрэвсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/33	Эрдэнэ сумын ЗДТГ	ажлын гүйцэтгэл дутуу санхүүжилт олгосон		24,520.0	Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/22	Эрдэнэ сумын ЗДТГ	Өвсний үнэ	19,800.0		Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/34	Дэлгэрхаан сум	данс бүртгэлд тусгаагүй		15,000.0	Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/11	Алтанбулаг сум	Ану сервис ХХК-ий гэрээний үлдэгдэл	6,000.0		Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/12	Алтанбулаг сум	Эс эм жи ти ХХК-ий ТХЗ, МАЗ, ЗТЗ	1,300.7		Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/45	Борнуур сум	Эко орчин эрүүл амьдрал ТББ-ын санхүүжилт		26,489.4	Ч.Загдсүрэн
ҮАГ-НАГ/2017/01-НА-01/45	Борнуур сум	Өргөө засал ХХК-ий ТХЗ, МАЗ, ЗТЗ	1,996.4		Ч.Загдсүрэн
	Алтанбулаг			29,963.0	Ч.Загдсүрэн

Архуст	данс бүртгэлд тусгаагүй		28,652.5	Ч.Загдсүрэн
Батсүмбэр			62,840	Ч.Загдсүрэн
Баянцогт			33,737	Ч.Загдсүрэн
Борнуур			39,500	Ч.Загдсүрэн
Дэлгэрхаан			15,000	Ч.Загдсүрэн
Лүн			28,000	Ч.Загдсүрэн
			33,097.1	392,522.4